

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
1401 дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Тээврийн цагдаагийн алба

Нэгжийн нэр:

Замын цагдаагийн газрын дүүргийн Замын цагдаагийн хэлтэс

Албан тушаалтны нэр:

Зөрчил хариуцсан ахлах байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-6

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

I. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

Албан тушаалын зорилго:

Харьяа нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэлтэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг хариуцаж, энэ чиглэлээр албаны бүтцийн болон харьяа нэгж, цагдаагийн төрөл мэргэжлийн бусад нэгж, алба хаагчтай харилцан ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Харьяа нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэлтэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг хариуцаж, энэ чиглэлээр албаны бүтцийн болон харьяа нэгж, цагдаагийн төрөл мэргэжлийн бусад нэгж, алба хаагчтай харилцан ажиллах.
2. Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврыг боловсонгүй болгох ажилд оролцох.
3. Хуулиар болон дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах —Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, үр дүнг тооцох танилцуулах.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа сайжирсан байна.	Г, Х
	1.2.Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр хэлтсийн алба хаагчдад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавих, энэ чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах.		Г, Т
	1.3.Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн, эргүүл хяналтын хуваарь, зохион байгуулалтыг өөрчлөх чиглэлээр санал өгөх.		Г, Т
	1.4.Хэлтсийн алба хаагчдаас зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй үйлчлэх, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтан, харьяа дүүргийн прокурор, шүүхийн байгууллагад хүсэлт, санал уламжлах, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах.		Г, Т
	1.5.Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, зөрчлийн хэргийг ердийн болон тусгай журмаар шалган шийдвэрлэх, энэ чиглэлээр хэлтсийн алба хаагчдад сургалт зохион байгуулах.		Г, Х

	1.6.Хэлтсийн даргын эзгүйд зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны чиг үүргийг хэрэгжүүлэх.		Г
	1.7.Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны чиглэлээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, явц үр дүнг танилцуулах;		Г, Т
	1.8.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр албаны бүтцийн болон харьяа нэгж, цагдаагийн төв байгууллагын холбогдох бусад нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчтай харилцан ажиллах.		Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийн зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх ажлын талаар танилцуулах;	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл боломж сайжирсан байна.	Г
	2.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох, эрх зүйн орчныг сайжруулах ажилд оролцож, санал танилцуулах;		Г
	2.3.Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, гадаад орнуудын туршлагыг судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажилд туслалцаа үзүүлэх.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, харьяа нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан хууль тогтоомж, захирамж, тогтоол, тушаал шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах;	Хэлтсийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна.	Г
	3.2.Замын хөдөлгөөний хяналт зохицуулалт, хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулж, дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, бусад байгууллагыг мэдээллээр хангах.		Г

	3.2.3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, шууд удирдах даргаас хариуцуулсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах;		Г
	3.4. Тээврийн цагдаагийн албаны болон хэлтсийн дотоод журмыг мөрдөж, өөрийн болон алба хаагч, байгууллагын аюулгүй байдлыг хангах, өмч, эд хөрөнгө, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, зарцуулалт, ашиглалтын журмыг мөрдөх;		Г
	3.5. Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ес зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдүүлэх, явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах;		Г
	6.3. Авлигын сэжигтэй тохиолдол бүрийг холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдээлэх.		Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- Эрх зүйч (0421)		
Мэргэшил	- Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	-Цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил, үүнээс офицерын албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; -Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй;	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох;	
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.	
	Бусад	-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх. -Монгол хэлний найруулга зүй, зөв бичих дүрмийн мэдлэгтэй байх; -Компьютерын өргөн хэрэглээний программ, дотоод сүлжээнд бүрэн ажиллах чадвартай байх; -Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын мэдлэгтэй байх; -Оффисын төхөөрөмжүүд дээр ажиллах чадвартай байх; -Зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар.	

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:
Батлагдсан орон тоо

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, Олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн. (Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална)

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Байгууллагын нэр:.....

Шийдвэрийн огноо:.....

Дугаар:.....

 Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр.

Дугаар: 401

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:.....

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр